



ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИ
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ТЭМДЭГЛЭЛ

2026 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Говь ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2026 оны 04-р сарын 29-ний өдөр Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороонд байрлах Говь ХК-ийн байр, Сургалтын танхимд танхимын хэлбэрээр 14:00-15:50 цагийн хооронд 89.41% ирцтэйгээр хуралдав.

Хурлын дарга:

ТУЗ-ийн хараат бус гишүүн Д.Гэрэлмаа

Хуралд оролцсон

компанийн төлөөллүүд:

ТУЗ-ийн хараат бус гишүүн А.Жаргалмаа
ТУЗ-ийн хараат бус гишүүн Д.Хүрэлбаатар
ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал Б.Амарсайхан
ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Сэлэнгэ
Менежмент багийн захирлууд
Хуулийн хэлтсийн дарга Г.Гантуяа
Кэй Пи Эм Жи Аудит ХХК-ийн менежер А.Өлзийжаргал

Хурлын тооллогын комисс:

Комиссын дарга

Нягтлан бодогч Б.Урангоо

Комиссын гишүүд

Нягтлан бодогч Ц.Амарзаяа

Нягтлан бодогч Б.Номин

Нягтлан бодогч Б.Ууганзаяа

Тогтвортой хөгжлийн ахлах менежер А.Гомбосүрэн

Тогтвортой хөгжлийн мэргэжилтэн Н.Чинсэтгэл

Хурлын ирц: Тооллогын комиссын дарга Б.Урангоо хурлын ирцийг танилцуулав.

Бүртгэлийн өдрөөр Говь ХК-ийн нийт саналын эрхтэй хувьцааны тоо 780,112,500 ширхэг байснаас хурлын материалтай урьдчилан танилцан санал өгөх арга хэлбэрээр 15,246,483 ширхэг хувьцааны 1.95 хувийн саналын эрхтэй 488 хувьцаа эзэмшигч, 04-р сарын 29-ний өдрийн хуралд биечлэн оролцох арга хэлбэрээр 682,252,889 ширхэг хувьцааны 87.46 хувийн саналын эрхтэй 50 хувьцаа эзэмшигч оролцсоноор нийт ирц 89.41 хувь болж хурлын ирц бүрдсэнийг Хурлын даргад мэдэгдэв.

Хурлын нээлт: Хурлын дарга Д.Гэрэлмаа хурлыг албан ёсоор нээж, хурлын дэг, хөтөлбөр, хэлэлцэх асуудлыг танилцуулав.

Танилцуулах асуудал:

1. Говь ХК-ийн 2025 оны санхүүгийн үр дүн болон үйл ажиллагааны тайлан;
2. 2025 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг тараахгүй тухай ТУЗ-ийн тогтоол;
3. ТУЗ-ийн 2025 оны ажлын тайлан.

Хэлэлцэх батлах асуудал:

1. ТУЗ-өөс компанийн 2025 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангийн талаар гаргасан дүгнэлт;
2. ТУЗ-ийн 2026 оны цалингийн төсөв.

Хурлаар танилцуулах асуудал болон хэлэлцэн батлах асуудлуудтай холбоотой материалыг хувьцаа эзэмшигчдэд тараан өгсөн бөгөөд тус агуулгын хүрээнд танилцуулгыг хийв.

ТАНИЛЦУУЛСАН НЬ:

1. Компанийн 2025 оны санхүүгийн үр дүн болон үйл ажиллагааны тайланг Гүйцэтгэх захирал Б.Амарсайхан танилцуулав.
2. 2025 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг тараахгүй тухай ТУЗ-ийн тогтоолын үндэслэлийг Гүйцэтгэх захирал Б.Амарсайхан танилцуулав.
3. ТУЗ-ийн 2025 оны ажлын тайлан, Нэр дэвшүүлэх хороо болон Цалин урамшууллын хорооны 2025 оны ажлын тайланг ТУЗ-ийн хараат бус гишүүн, Нэр дэвшүүлэх хорооны дарга Д.Гэрэлмаа танилцуулав. Эрсдэл, аудитын хорооны 2025 оны ажлын тайланг ТУЗ-ийн хараат бус гишүүн, Эрсдэл, аудитын хорооны дарга А.Жаргалмаа танилцуулав.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

1. ТУЗ-өөс компанийн 2025 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангийн талаар гаргасан дүгнэлтийг ТУЗ-ийн хараат бус гишүүн Д.Гэрэлмаа танилцуулав.
2. ТУЗ-ийн 2026 оны цалингийн төсвийг ТУЗ-ийн хараат бус гишүүн Д.Гэрэлмаа танилцуулав.

СОНССОН НЬ:

(АСУУЛТ, ХАРИУЛТ, САНАЛ)

1. Хувьцаа эзэмшигч Мөнхжаргал: Би 2018 оноос хойш хувьцаа эзэмшиж байна. Надад 2 асуулт байна.

1. Говь ХК-ийн дүрмийн 6.2.8 хэсэгт ТУЗ-ийн ээлжит хурлыг 2 сард нэг удаа хуралдуулна гэж заасан байна. Жилд ээлжит хурал багадаа 6 удаа хийгдэхээр байна. Өнгөрсөн жил ээлжит хурал 2 удаа, ээлжит бус хурал 3 удаа хийгдсэн байна. Нийт 5 удаа хуралдсан байна. Тэгэхээр ТУЗ-ийн гишүүд дүрмээ баримталдаг юм уу? Хурал хийж ажлаа хийдэг юм уу?
2. 2026 онд үргэлжлээд ажиллах юм байна. Дахиад хурал дүрэмд заасан хэмжээгээр хуралдахгүй бол яах вэ? Цалин хөлсийг олгоод байх юм уу? энэ дээр хариулт авмаар байна.

Хурлын дарга Д.Гэрэлмаа: Асуултыг хүлээж авлаа. Асуултын хариултыг Сэлэнгэ /ТУЗ-ийн нарийн бичгийн дарга/ хариулна.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Сэлэнгэ: Сайн байна уу, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Сэлэнгэ байна.

Таны асуултад дурдсан компанийн дүрмийн заалт бол өмнөх дүрэм дээр заагдсан заалт байна. Бид 2025 оны 4-р сарын 25-нд болсон Хувьцаа эзэмшигчдийн хурлаар компанийнхаа дүрмийг шинэчилж батлан, ТУЗ-ийн хурлыг улиралд 1 удаа хийнэ гэсэн байдлаар өөрчлөлт оруулсан. Хурлын хувьд бид бүхэн төлөвлөгөөний дагуу хурлуудаа зохион байгуулдаг. 2025 оны 9-р сард Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал зарлаж компанийн хэлбэр өөрчлөх шийдвэрийг гаргасан. Үүнтэй холбоотой оны сүүлд төлөвлөгдөж байсан ээлжит хурал хуралдаагүй хойшлогдсон. Харин 2026 оны хувьд бид жилд 4 удаа хуралдана гэдгээр төлөвлөгөөндөө тусгаад төлөвлөгөөнийхөө дагуу энэ онд 2 хурал зохион байгуулсан явж байна. Нэмэлт асуулт байвал асууж болно шүү.

2. Хувьцаа эзэмшигч Мөнхжаргал: Таны тайлбар дээр ХХК болж өөрчлөх процесстэй холбоотой зүйл гарлаа. Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ)-оос ХХК болох процессыг зогсоосон шалтгааныг веб сайт дээрээ дэлгэрэнгүй бичсэн байгаа. Гоёо компанийг худалдан авахдаа үнэлгээ хийгээгүй, аудит оруулаагүй байна. Энэ бол жижиг хувьцаа эзэмшигчдийн

эрхийг зөрчиж байна. Энийг шалгаж шийдээд, хуулийн дагуу жижиг хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалсны дараа энэ асуудлаа дахиж тавь гэсэн. Та бүхэн тайлан дээрээ одоо бид нар зөвшөөрлөө хүлээж байгаа юм шиг юм бичээд байна. Энэ талаарх мэдээллийг өгнө үү.

Хурлын дарга Д.Гэрэлмаа: Асуултыг хүлээж авлаа. Маш тодорхой асуулт тавьсан. Хуулийн хэлтсийн дарга Г.Гантуяа хариулна.

Хуулийн хэлтсийн дарга Г.Гантуяа: СЗХ-оос Говь ХК-д хяналт шалгалт орсон. Энэ асуудалтай холбоотой жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаална гэдэг байдлаар СЗХ тайлбарлаж байгаа. Харин компанийн зүгээс энэхүү хяналт шалгалтын тайлан нь хуульд нийцэж гарсан уу, үгүй юу гэсэн асуудал дээр шүүхээс дүгнэлт гаргуулахаар шүүхийн процессын ажиллагаа явагдаж байгаа.

Хувьцаа эзэмшигч Мөнхжаргал: Шүүхийн мэдээлэл өгөөрэй. Ямар шатандаа явж байгаа вэ?

Хуулийн хэлтсийн дарга Г.Гантуяа: Компанийн зүгээс 4 нэхэмжлэлийн шаардлага гаргасан. СЗХ хариуцагчаар татагдсан байгаа. Одоо нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх процесс дээр явж байна.

Хувьцаа эзэмшигч Мөнхжаргал: Хувьцаа эзэмшигчдээс гуравдагч этгээдээр орж байгаа юу?

Хуулийн хэлтсийн дарга Г.Гантуяа: Одоогоор шүүхээс гуравдагч этгээдээр оролцуулахаар захирамж гараагүй байна.

3. Хувьцаа эзэмшигч Бямбадорж: Өдрийн мэнд хүргэе. Хувьцааны төвлөрөл одоо 87.44 хувь болсон байна. Хувьцааны зах зээлийн ханш 220 орчим төгрөг болоод бараг жил боллоо. Хувьцаа буцааж худалдан авч байгаа хөтөлбөр хэрэгжиж байгаа юу? Энэ зардал санхүүгийн тайланд тусгагдсан зардалд орсон байгаа юу? Өөрөөр хэлбэл, үйл ажиллагааны бус зардал 54 тэрбум төгрөг байна. Би бодохдоо банкны зээлийн хүү ихэнхийг эзлээд, үндсэн төлбөрөөсөө төлөгдөхгүй байх шиг байна. Үлдсэн зардал нь ямар зардлууд байдаг вэ? Үйл ажиллагааны бус зардал компанийг ашиггүй харагдуулаад байна. Их хэмжээний зээлтэй байна. Би хувь хүнийхээ зүгээс бус арилжаа эрхлэгчийн хувьд шийдвэр гаргахад нөлөөлөх учир асууж байна. Иймд санхүүгийн хүн хариулж өгөхийг хүсье.

Хурлын дарга Д.Гэрэлмаа: Баярлалаа. Манай Содгэрэл захирал хариулна.

Бүртгэл хариуцсан захирал Д.Содгэрэл: Сайн байцгаана уу? Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Таны асуултын дагуу хувьцаа худалдаж аваагүй байгаа. Хувьцаа худалдаж авсан тохиолдолд ч хөрөнгө оруулах зардлыг компани бус Таван Богд Холдингс ХХК гаргах байгаа. Санхүүжилтийн зардлын хувьд 54.9 тэрбум төгрөгийн зардал гаргасан. Үүн дотроо зээлийн хүүгийн зардал 24.6 тэрбум төгрөг. Мөн бусад голлон эзэлж байгаа зардлын хувьд бид гадаадын банкнуудаас санхүүжилт авсантай холбоотой валютын ханшийн гарз буюу алдагдал 20 тэрбум, бусад өр төлбөрийн хүү буюу холбоотой талаас авсан зээл, санхүүжилтэд 5.2 тэрбум төгрөгийг төлсөн байгаа.

4. Хувьцаа эзэмшигч Баянцагаан:

1. Өмнөх хувьцаа эзэмшигчийн асуусан үйл ажиллагааны бус зардал 54.9 тэрбумыг задлаад оруулдаг бол сайн байна. Өр төлбөр 324.4 тэрбум төгрөг гэж баланс дээр байна. Яагаад өр тавьсан бэ?
2. Хурлын материалын 34-р хуудсан дээр байна. Борлуулалтын орлогын татварын өмнөх ашиг гээд 4.8 тэрбум төгрөг түүнээс 4.7 тэрбум төгрөгийг орлогын албан татварын зардал гэж хасаад нийт гарах цэвэр ашгаа бууруулсан байна. Энэ тооцоололд алдаа байна уу, 90 гаруй хувийн ашгийн татвар төлдөг юм уу? Хэрэв онцгой татвар төлдөг бол ийм гарч магадгүй, гэхдээ энэ их сонирхолтой асуудал байна.
3. Орлогын зардал дээр өөрийн өртгийн задаргааг хийж өгвөл хүмүүст ойлгомжтой болов уу гэж бодож байна. Түүний цаана юу байгааг мэдэхгүй байна.

4. Борлуулалтын орлогын явц дунд 23.8 тэрбум төгрөгийн ханшийн зөрүү гарлаа гэж байна. Валютын ханшийн зөрүү Монголд ханш өссөн болохоос буусан тохиолдол байхгүй. Би өөрөө ББСБ эрхэлж явдаг хүн. Ийм сонин тоо гарч ирсэн байна.
5. Энд сууж байгаа улсууд тодорхой хэмжээний өөрийн хөрөнгөнөөс өгсөн. Үүнийг өсгөөд мөнгө болгож өгнө гээд итгээд худалдаж авах нь аваад, цэнхэр тасалбараа өгөх нь өгсөн. Ногдол ашиг олгох талаар ямар ажил зохион байгуулсан бэ? Алдагдалд юу нөлөөлсөн бэ?

Хурлын дарга Д.Гэрэлмаа: Баярлалаа. Манай Содгэрэл захирал хариулна.

Бүртгэл хариуцсан захирал Д.Содгэрэл: 2025 онд нийт 324 тэрбум төгрөгийн өр төлбөртэй байгаагийн 88% буюу 290 тэрбум төгрөгийг гадаадын болон дотоодын банкны зээл эзэлж байгаа. Та бүхэн зээлийн дэлгэрэнгүй мэдээлэл буюу аль банканд ямар зээлтэй, ямар хүүтэй байгааг хурлын материалаас дэлгэрэнгүй харж болно. Мөн өр төлбөрийн хувьд хойшлогдсон татварын өглөг 17 тэрбум төгрөг байгаа нь нийт өр төлбөрийн 6%-ийг эзэлж байна. Энэ нь санхүүгийн тайлангийн зорилгоор хэрэгжээгүй өр төлбөр байгаа. Дансны болон бусад өглөг 10 тэрбум төгрөг байгаа. Энэ нь манайх гадаадаас бараа материалын татан авалт хийдэгтэй холбоотой хугацаандаа төлөгдөх хуваарьт өглөг байгаа.

Татварын зардлын хувьд Говь ХК нийт 246 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн. Үүнд татварын холбогдох хууль тогтоомжийн тооцооллын дагуу Татварын ерөнхий газарт орлогын албан татварын өглөг 4.7 тэрбум төгрөгийг төлөхөөр тайлагнасан бодит дүн байгаа. Татварын зардал нь хойшлогдсон татварын зардал, орлогын албан татварын зардал гээд 2 төрөл байдаг. Орлогын албан татварын зардал нь 1.5 тэрбум төгрөг, хойшлогдсон татварын зардал 3 тэрбум төгрөг гээд 4.7 тэрбум төгрөгийн зардлыг тайлагнасан. Энэ нь татварын байгууллагаар баталгаажсан дүн.

Гадаад валютын ханшийн зөрүүний хувьд, гадаадад манай охин компаниуд байгаа. Охин компаниуд маань тухайн улсдаа валютаараа тайлангаа тайлагнадаг. Нэгтгэл тайлангийн зорилгоор Монгол Улсад төгрөгөөр илэрхийлэгдэх ёстой байдаг. 2019 оноос хойш бид охин компаниа гадаадад байгуулсантай холбоотой түүхэн ханш болон хаалтын ханш хоёрын зөрүүнээс үүссэн ханшийн зөрүү байгаа. Эдгээр тайлангууд бол KPMG аудитаар аудитлагдсан бодит үр дүн байгаа. Бид тайлан дээр ямар нэг тоо буруу тайлагнаагүй.

5. Хувьцаа эзэмшигч Бадамсүрэн: Сайн байцгаана уу. Эхлээд асуулт асуухаас өмнө нэг санал гаргамаар байна. Хурлын процессын санал асуултад хорьхон минут тавьсан байна. Үнэхээр амжихгүй. Жилд ганц удаа Хувьцаа эзэмшигчдийн хурал болж байгаа. Одоо 6 минут дутуу байна, энд олон хүмүүс асуулт асуумаар байна, хариулт авмаар байна. Энэ цагаа сунгаж өгөөрэй.

Говь ХК Монголдоо Топ 10 аж ахуй нэгжид багтдаг. Гэтэл Топ 10-т багтаж байгаа компани ногдол ашиг хуваарилж чадахгүй гээд хувьцаа эзэмшигчидтэй хурлаа хийгээд сууж байна. 2018 оноос хойш ногдол ашиг хуваарилаагүй. Ковидын шалтгааныг хэлж байна, Топ 10-т ордог Говь битгий хэл бусад хувийн компани Ковидын эрсдэлийг нөхдөгөө нөхөөд, ашигтай ажиллаад ногдол ашиг хуваарилаад явж байгаа. Сая компанийн бүтцийг харлаа, хамгийн нэг номерт Хувьцаа эзэмшигчид эрхтэй байдаг юм байна. Хоёрт Төлөөлөн удирдах зөвлөл байдаг юм байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолыг Хувьцаа эзэмшигчид хүлээж авахгүй байх үндэслэлтэй байдаг юм байна.

1. ТУЗ-ийн гишүүдийг ямар шалгуураар сонгодог вэ? Яагаад улираад явж байгаа вэ? Би хувьцаа эзэмшигч хүнийхээ хувьд ТУЗ муу ажилласан байна гэж хэлэх гэж байна. Хувьцаа эзэмшигчдэдээ мэдээлэл өгөөгүй байна. ТУЗ-ийн хурлын мэдээлэл, ямар шийдвэр гарсныг яагаад бидэнд и-мэйлээр ирүүлдэггүй вэ, бид ямар ч мэдээлэлгүй хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож байна.

2. ТУЗ-ийн Нэр дэвшүүлэх хороо, Цалин урамшууллын хороо, Эрсдэл, аудитын хороонд яагаад ТУЗ-ийн гишүүд өөрсдөө орсон байгаа вэ? Яагаад өөрсөд дээрээ цалин бодоод тогтоол гаргаад явж байгаа вэ? Үйл ажиллагааг хариуцсан хяналтын зөвлөл байдаггүй юм байна.
3. Хараат бус гишүүдийг ямар шалгуураар сонгодог вэ? Нээлттэй яагаад зарладаггүй вэ? Бид нар яагаад орж болдоггүй вэ?
4. Ногдол ашиг хуваарилахгүй гэсэн тогтоолыг хувьцаа эзэмшигчид хүлээж авах боломжгүй байна.

Хурлын дарга Д.Гэрэлмаа: За, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Сэлэнгэ хариулна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга М.Сэлэнгэ: Хараат бус гишүүдийн шалгуурыг Компанийн тухай хуулийн 79-р зүйлд тодорхой заасан байдаг. Хуулийн заалттай уялдуулж манай Нэр дэвшүүлэх хорооноос “ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх журам” боловсруулсан байдаг. Тэр журмын дагуу сонгон шалгаруулалт хийгээд, шалгуур хангасан хүнийг томилдог. Манай компани 2024 оны 9 дүгээр сард хараат бус гишүүний сонгон шалгаруулалтыг нээлттэй зарлаж зохион байгуулсан байгаа. Шаардлага гарсан тохиолдолд нэмэлтээр сонгон шалгаруулалт зарладаг. ТУЗ-ийн гишүүдийг 3 жилийн хугацаатай томилдог.

ТУЗ-ийн хороодын бүрэлдэхүүний талаар та асуулаа. Компанийн тухай хуульд ТУЗ нь 9 болон түүнээс дээш гишүүнтэй байна гэж заасны дагуу манай компани 9 гишүүнтэй байдаг. ТУЗ-ийн дэргэд 3 хороо байх ёстой гэсэн хуулийн шаардлагын дагуу 3 хороо байгаа. Мөн хуулийн дагуу ТУЗ-ийн дэргэдэх хороод 3-аас доошгүй ТУЗ-ийн гишүүдээс бүрдэх ёстой байдаг ба түүний 2-оос доошгүй нь хараат бус гишүүн байх ёстой байдаг. Энэ шалгуурын дагуу манай ТУЗ болон хороод бүтэц бүрэлдэхүүнтэй байгаа.

Ногдол ашигтай холбоотой ТУЗ-өөс баталсан “Ногдол ашгийн журам” байдаг. Тухайн журмын 2-р бүлэгт ногдол ашгийн бодлогыг заасан байдаг. Та бүхэнд тарааж өгсөн хурлын материал дээр мөн ногдол ашгийн бодлогыг оруулсан байгаа. Бодлого дээр Компанийн тухай хуулийн 47-р зүйл, Компанийн дүрмийн 8-р зүйлийн 8.12-т заасан нөхцөл хангагдсан үед ногдол ашгийг хуваарилна гэж заасан байдаг. Тухайн нөхцөлийг дурдвал, хамгийн том шалгуур нь ногдол ашиг төлсний дараа компани төлбөрийн чадвартай байх ёстой. Мөн ногдол ашиг төлсний дараа компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, түүний татан буулгалтын үнэ зэргийн нийлбэрээс их байх зэрэг үндсэн шалгуурууд байдаг. Энэ шалгууруудын дагуу жил болгон 2 дугаар сарын 19-ний дотор ТУЗ-ийн хурлаар хэлэлцэж ногдол ашиг хуваарилах шийдвэрээ гаргадаг. Энэ жилийн хувьд энэ журмаар хэлэлцээд санхүүгийн үр дүн нь санхүүгийн зохистой харьцааг хангахгүй байгаа учраас ногдол ашиг зарлахгүй гэсэн шийдвэр гаргасан. Бид Монголын хөрөнгийн биржийн цахим хуудас болон компанийн хуудсаар дамжуулан мэдээллийг тухай бүр ил тод хүргэдэг. ТУЗ-ийн хурлын шийдвэрүүдийг Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсанд тухай бүр байршуулж мэдээллийн ил тод байдлаа хангаад явдаг.

Хурлын дарга Д.Гэрэлмаа: Асуулт хариултын хэсгийн цаг дуусаж байна. Бид хурлын дэг, хөтөлбөр болон хэлэлцэх асуудалтай холбоотой материалыг хуулийн хугацаандаа урьдчилан та бүхэнд хүргэсэн байгаа. Мөн бид жилийн турш хувьцаа эзэмшигчдээсээ саналыг нь бичгээр, цахимаар, утсаар гэх мэт бүх арга хэлбэрээр авдаг. Хурлын товлосон үргэлжлэх хугацаа 2 цаг байгаа. Та бүхний санал бидэнд маш чухал гэдгийг дахин хэлье. Завсарлагааны хугацаанд та бүхэн бидэнтэй уулзаж асууж тодруулах зүйлээ асуухад бид нээлттэй байна. Манай удирдлагын баг бүрэн бүрэлдэхүүнээрээ байгаа. Мөн та бүхнийг орж ирэхэд санал хүсэлтийн цаас өгсөн байгаа. Засаглал, ТУЗ-тэй холбоотой санал хүсэлтээ бичгээр бидэнд ирүүлж болно. Үүний дагуу манай ТУЗ болон ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хариуг хурдан шуурхай өгөх дээр анхааран ажилладаг гэдгийг хэлмээр байна.

6. Хувьцаа эзэмшигч: Өнгөрсөн жилийн Хувьцаа эзэмшигчдийн хурал дээр мөн миний бие хэдэн асуултыг тавьж байсан.

1. Компани хаалттай болох гэж байгаа эсэх, мөн энэ жил ашигтай ажилласан тохиолдолд ногдол ашиг олгох эсэх гэсэн маш тодорхой хоёр асуултыг өнгөрсөн жил асууж байсан. Гэвч энэ жил ийм байдалтай байна. Иймд өгсөн амлалтдаа хүрч ажиллахыг хүсэж байна. Та бүхэн Монголын топ компаниудын нэг шүү дээ.
2. Гүйцэтгэх захирал Б.Амарсайхан томоохон гэмт хэргийн асуудалд холбогдсон байхад яагаад ёс зүйн хариуцлага хүлээхгүй байгаа юм бэ? Үүнээс шалтгаалан компанийн нэр хүндэд сөргөөр нөлөөлж, гадаад болон дотоод борлуулалт буурч байна гэж харж байна. Мөн шүүхийн шийдвэрийн дагуу төлөгдсөн олон зуун сая төгрөгийн зардал компаниас гараагүй гэдгийг бид аудитын компаниас тодруулж асуумаар байна. KPMG өнөөдөр тайлангаа тавих ёстой. Гэтэл ТУЗ өмнөөс нь дүгнэлтээ уншаад явж байна.
3. Өнгөрсөн жил ажилтнуудын тоо буурсан гэсэн мэдээлэл гарсан. Компанийн дотоод шүгэл үлээх системээр санал, хүсэлт гаргасан хүмүүсийг ажлаас халсан гэх мэдээлэл үнэн үү? Менежментийн хувьд бүтцээ зөв болгож байгаа нь сайн байна, гэхдээ үүн дээр тодорхой хариулт авахыг хүсэж байна.
4. ТУЗ-ийн хараат бус гишүүд хэчнээн компанийн ТУЗ-д байдаг вэ? Цалин авч ажиллаж байгаа атлаа яагаад хараат бусаар ажиллаж чадахгүй байна вэ? Эрсдэл, аудитын хорооны дарга Жаргалмаа яагаад СЗХ-ны тайлантай холбоотой асуудлууд дээр тодорхой дүгнэлт, шийдвэр гаргаж танилцуулахгүй байна вэ?
5. Дотоод холбоотой этгээдүүдээс зээл аваад, ашиггүй ажиллуулаад, энэ компанийг зориуд дампууруулах үйл ажиллагааг 6-7 жил хийгээд, хувьдаа авах гэж байгаа юм уу? Хэрэв хувьдаа авах бол хувьцаагаа өндөр үнээр авахыг хүсэж байна. Танай компанийн үнэлгээ одоо бага байгаа.

Хурлын дарга Д.Гэрэлмаа: Бид хурал хийж байгаа учир ойлголцох нь хамгийн чухал. Говь ХК нь сайн засаглалын жишгийг хэрэгжүүлэн ажиллаж байгаа компани. Сайн засаглал гэдэг нь бид аливаа шийдвэрийг үргэлж дүрэм, журмынхаа дагуу гаргадаг бөгөөд хэн нэгний хувийн үзэл бодолд үндэслэн шийдвэр гаргах эрх энэ компанид ажиллаж байгаа хэнд ч байдаггүй гэдгийг хариуцлагатайгаар хэлж чадна. Таны асуултад холбогдох удирдлагууд хариултыг өгөх болно.

Бүртгэл хариуцсан захирал Д.Содгэрэл: Холбоотой талын зээл, санхүүжилтийн асуудлын хүрээнд бид үйл ажиллагаагаа сайжруулах зорилгоор арилжааны банкны хүүгээр буюу 15.6 хувийн хүүтэй санхүүжилт авч ашиглаж байгаа. Үйл ажиллагааны нөхцөл байдал сайжрах үед тухайн санхүүжилтийг гэрээний нөхцөлийн дагуу эргэн төлдөг бөгөөд энэ нь хууль, журмын хүрээнд хийгддэг. Үүнд ямар нэгэн давуу байдал, онцгой нөхцөл байхгүй. Энэ дээр KPMG аудитаас мөн дүгнэлт гаргасан байгаа.

Мөн бид улирал тутам СЗХ-нд тайлангаа тогтмол хүргүүлдэг. Гүйцэтгэх захиралтай холбоотой асуудлын хувьд компанийн зүгээс ямар нэгэн төлбөр, мөнгөн зардал гараагүй болно. Энэ тухай KPMG аудитын зүгээс мөн нэмэлт тайлбар авах боломжтой.

Кэй Пи Эм Жи Аудит ХХК-ийн менежер А.Өлзийжаргал: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Манай KPMG аудит компани нь Говь ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд аудит хийх гэрээт ажлыг гүйцэтгэсэн.

2025 оны аудитын шалгалтын үр дүнд Говь ХК-ийн санхүүгийн тайланд ямар нэгэн материаллаг алдаа илрээгүй гэсэн дүгнэлт гарсан. Шалгалтын хүрээнд олон асуудлыг хамруулж байгаагийн нэг нь компанийн оролцож байгаа зарга, маргаан, хэрэг байгаа эсэх, түүний үр дүнд компанид үүсэж болох өр төлбөр гэх мэт асуудлыг хамруулдаг. Шалгалт хийсэн хугацаанд Говь ХК-аас бусад этгээдтэй холбоотойгоор хувь хүний өмнөөс оролцсон, эсхүл компанийн өмч хөрөнгөөс гарсан ямар нэгэн зардал, төлбөр байгаагүй гэдгийг хэлмээр байна.

ТУЗ-ийн хараат бус гишүүн А.Жаргалмаа: Миний бие Говь ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр 2020 онд сонгогдон, өнөөдрийг хүртэл ажиллаж байна. Эрсдэл, аудитын хороог даргалж ажиллаад 4 жил орчим болж байна. Хараат бус байдлаа алдсан уу гэсэн асуулт ирсэн. Миний зүгээс хараат бус байдлаа алдаагүй гэж дүгнэж байна. Мөн нэмэлтээр хэлэхэд, өөр ямар нэгэн компанийн ТУЗ-ийн гишүүнээр ажилладаггүй болно. СЗХ-оос гаргасан тайлантай танилцаж, 2018-2019 оны худалдан авалттай холбоотой мөн танилцсан. Эрсдэл, аудитын хорооны зүгээс хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хангах үүднээс шалгалт оруулах талаар хувьдаа бодож, компанийн зүгээс холбогдох мэдээллийг авсан. Уг мэдээлэлд үндэслэн Гоёо ХХК-ийг худалдан авах ажиллагааг хянан үзэхэд бүх үйл явц хууль, журмын дагуу хэрэгжсэн гэсэн мэдээллийг авсан. Тиймээс яаран шалгалт оруулах ажлыг эхлүүлээгүй. Мөн компанийн зүгээс СЗХ-ны тайлан шийдвэртэй холбоотой маргаантай асуудал байгаа тул тухайн асуудал эцэслэн шийдвэрлэгдэх хүртэл түр хойшлуулсан байна. Өөрөөр хэлбэл энэ асуудлыг авч үзсэн, хараат бус гишүүнийхээ хувьд бодолцож үзсэн.

Хүний нөөц хариуцсан захирал Т.Ичинхорлоо: 2025 оны турш компанийн бүтцийг зөв, оновчтой болгох хүрээнд зарим газар, нэгжүүдийг татан буулгах, нэгтгэх ажлуудыг үе шаттай хэрэгжүүлсэн. Мөн Гүйцэтгэх захирлын тайланд дурдсаны дагуу дижитал шилжилт болон олон төрлийн системүүдийг нэвтрүүлсэн. Үүний хүрээнд үйлдвэрийн ажилтнуудын гар ажиллагааг бууруулах, бүтээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр тодорхой ажлуудыг хийж хэрэгжүүлснээр бүтээмж сайжирсан. Үүнтэй холбоотой ажилтнуудынхаа тоог тодорхой хэмжээнд цөөрүүлсэн. 2025 онд нийт 200 орчим ажилтны орон тооны цомхотгол хийгдсэн бөгөөд уг үйл ажиллагааг Хөдөлмөрийн тухай хуульд нийцүүлэн зохих журмын дагуу хэрэгжүүлж, 341 сая төгрөгийг тэтгэмжид олгосон.

Шүгэл үлээх системтэй холбоотойгоор ажилтнуудыг ажлаас халсан асуудал огт гараагүй. Говь ХК-аас гарсан ажилтнууд бүгд хуульд заасан зохих тэтгэмж, олговрыг авч гарсан бөгөөд энэ хүрээнд ямар нэгэн хөдөлмөрийн маргаан, гомдол, санал гараагүй болно.

Гүйцэтгэх захирал Б.Амарсайхан: Миний бие холбогдох хууль, журмын дагуу тухайн хэрэгтэй холбоотой хариуцлагаа хүлээсэн. Шүүх хуралдаантай холбоотой компани болон хувьцаа эзэмшигчдэд ямар нэгэн хохирол учруулаагүй бөгөөд аливаа зардал, төлбөрийг компаниас гаргуулаагүй. Уг төлбөр, зардлыг 100 хувь өөрийн болон ар гэрийн зүгээс бүрэн хариуцан барагдуулсан.

Хөтлөгч: Та бүхэндээ баярлалаа. Асуулт хариултын хэсэг энд хүрээд өндөрлөж байна. Танд нэмэлт асуулт болон санал хүсэлт байвал таныг бүртгүүлэхэд өгсөн жижиг санал хүсэлтийн хуудсанд бичээд санал хүсэлтийн хайрцагт хийнэ үү. Санал хүсэлтийн хайрцаг нь танхимын ард хэсэгт, Тооллогын комиссын ширээн дээр байрлаж байна. Гүйцэтгэх удирдлагын баг болон ТУЗ-ийн түвшинд та бүхний санал хүсэлтийг хэлэлцээд, эргэж хариу өгөх болно гэдгийг хариуцлагатайгаар хэлье.

САНАЛ ХУРААЛТ

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Сэлэнгэ санал өгөх зааврыг танилцуулан, санал хураалтыг албан ёсоор нээж санал хураалт нийт 8 минут үргэлжлэв.

САНАЛ ХУРААЛТЫН ДҮНГ НЭГТГЭХ

Тооллогын комисс саналын хайрцгийг задлан, санал хураалтын дүнг нэгтгэв. Энэ хугацаанд хурал түр завсарлав.

Хөтлөгч: Саналыг нэгтгэж дууссан тул санал хураалтын дүнг танилцуулж, тогтоолыг батлуулна уу хэмээн Тооллогын комиссын дарга Хатагтай Урангоог та бүхний өмнө урьж байна.

САНАЛ ХУРААЛТЫН ДҮНГ ТАНИЛЦУУЛАХ

Тооллогын комиссын дарга Б.Урангоо танилцуулав.

Монгол улсын Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3, Компанийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.1.10-6.1.16 дахь заалтыг тус тус удирдлага болгон 2026 оны 04-р сарын 29-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын санал хураалтын дүнг нэгтгэн тоолсныг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Нийт **89.41** хувийн саналын эрхтэй **697,493,612** ширхэг хувьцааны **534** ширхэг саналын хуудас хураасныг тооцсугай.
2. 2026 оны 04-р сарын 29-ний өдөр санал хураах хайрцгаар **87.45** хувийн саналын эрхтэй **682,247,159** ширхэг хувьцааны **46** ширхэг саналын хуудас хураасныг дурдсугай.
3. Урьдчилан санал өгөх хэлбэрээр **1.95** хувийн саналын эрхтэй **15,246,483** ширхэг хувьцааны **488** ширхэг саналын хуудас хураасныг дурдсугай.
4. Нийт саналын хуудаснаас **0.00** хувийн саналын эрхтэй **8,120** ширхэг хувьцааны **7** ширхэг саналын хуудас хүчингүй болсныг дурдсугай.
5. Говь ХК-ийн 2025 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангийн талаар Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг хуралд оролцогчдын **99.99** хувийн саналаар баталсныг мэдэгдсүгэй.
6. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны цалингийн төсвийг батлах тухай асуудлыг хуралд оролцогчдын **99.99** хувийн саналаар баталсныг мэдэгдсүгэй.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Сэлэнгэ: Баярлалаа. Хурлаас гарах тогтоолын төсөлд санал хураалтын дүнг тусган танилцуулж, батлуулъя.

ХУРЛААС ГАРАХ ТОГТООЛЫГ ТАНИЛЦУУЛАХ

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Сэлэнгэ тооллогын комиссын санал хураалтын үр дүнд үндэслэн хурлаас гарах дараах 2 тогтоолын төслийг танилцуулав.

1. Компанийн 2025 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай
2. ТУЗ-ийн 2026 оны цалингийн төсвийг батлах тухай

ХУРЛЫН ХААЛТ

Хөтлөгч: Өнөөдрийн хуралдаанд цаг заваа гарган хүрэлцэн ирж идэвхтэй оролцон, өөрсдийн санал хүсэлтийг чөлөөтэй илэрхийлсэн хувьцаа эзэмшигчдэдээ маш их баярлалаа.

Та бүхний санал хүсэлтийг Гүйцэтгэх удирдлагын баг, Төлөөлөн удирдах зөвлөлийн зүгээс хүлээн авч хэлэлцээд, холбогдох хариуг нь мэдэгдэх болно.

Ийнхүү Говь ХК-ийн 2026 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал өндөрлөж буйг албан ёсоор мэдэгдье. Хүрэлцэн ирсэн та бүхэндээ баярлалаа.

Хурал 15 цаг 50 минутад өндөрлөв.

ХЯНАСАН:

Хурлын дарга



Д.ГЭРЭЛМАА

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга



М.СЭЛЭНГЭ